

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэх арга, хяналт, үйл ажиллагаандаа мөрдөх онцлог зохицуулалтыг бий болгоход оршино.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хууль тогтоомж

2.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль², Компанийн тухай хууль³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, хяналт, ил тод байдал болон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

¹Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

³Компанийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

3.3.Тухайлсан хуулийн дагуу байгуулагдсан төрийн өмчит компанийн үйл ажиллагааг тухайн хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасны дагуу зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."төрийн өмчийн хувьцааг удирдах этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын шийдвэрийн үндсэн дээр төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага, эсхүл төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

4.1.2."орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн дагуу орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх тухайн шатны Засаг даргыг.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмших зорилго, зарчим

5.1.Төр нийтийн ашиг сонирхлын үүднээс чиг үүргээ хэрэгжүүлэх, хууль тогтоомж, компанийн дүрэм, гэрээнд заасан бизнесийн онцлог үйл ажиллагааг эрхлэх зорилгоор компанийн хувьцаа эзэмших ба энэ тохиолдолд хариу төлбөртэйгээр бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, ажил, үйлчилгээ үзүүлэх замаар боломжит хэмжээгээр ашигтай ажиллахыг зоринo.

5.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг эзэмших, удирдах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.2.1.ашигтай ажиллах;

5.2.2.хараат бус байх;

5.2.3.компанийн үйл ажиллагаа ил тод байх;

5.2.4.компанид хамаарах бүх хөрөнгөд хариуцлага хүлээх;

5.2.5.компани төрийн хүлээх үүргийг хариуцахгүй байх.

5.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь компанийн сайн засаглалын зарчмыг дагаж мөрдөх бөгөөд хяналт, удирдлагын дараах зарчмыг баримтална:

5.3.1.төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх Засгийн газрын бүрэн эрхээс хувьцаа эзэмшигчийн эрх тусгаарлагдсан байх;

5.3.2.орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхээс хувьцаа эзэмшигчийн эрх тусгаарлагдсан байх;

5.3.3.хараат бус хөндлөнгийн хяналттай байх;

5.3.4.үр ашиггүй зардал гаргахгүй байх;

- 5.3.5.санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах;
- 5.3.6.хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх.

5.4.Төр хувьцааг нь эзэмшиж байгаа нэг компанид нэг төрийн захиргааны төв байгууллага, эсхүл төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.

5.5.Хязгаарлагдмал хариуцлага хүлээхээс бусад тохиолдолд төр гадаадын хуулийн этгээдтэй хувийн эрх зүйн хүрээнд компани байгуулах замаар хамтран ажиллахыг хориглоно.

6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ангилал

6.1.Төрийн өмчит компанийг дараах байдлаар ангилна:

6.1.1.төр бүх хувьцааг нь эзэмшдэг төрийн өмчит компани;
6.1.2.төр хяналтын багцаас 99 хувь хүртэлх хувьцааг нь эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой компани.

6.2.Орон нутгийн өмчит компанийг дараах байдлаар ангилна:

6.1.3.орон нутаг бүх хувьцааг нь эзэмшдэг орон нутгийн өмчит компани;

6.1.4.орон нутаг хяналтын эрхтэй багцаас 99 хувь хүртэлх хувьцааг нь эзэмшдэг орон нутгийн өмчийн оролцоотой компани.

6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг ач холбогдлоор нь стратегийн ач холбогдолтой компани болон нийтийн үйлчилгээг зайлшгүй хүргэх компани гэж ангилж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИ БАЙГУУЛАХ

7 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах

7.1.Компанийг шинээр, эсхүл хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар байгуулж болно.

7.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн үүргийг төр хүлээх бөгөөд хувьцааг худалдах, шилжүүлэх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах салбар

8.1.Төрийн өмчит компанийг дараах салбарт үүсгэн байгуулж болно:

8.1.1.стратегийн ач холбогдол бүхий салбар;
8.1.2.хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэх боломжгүй нийтийн үйлчилгээний тодорхой салбар;

8.1.3.хуульд тухайлан заасан.

8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.

8.3.Орон нутгийн өмчит компанийг хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэх боломжгүй, эсхүл хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгүүлэхээс илүү санхүүгийн үр ашигтай байх бол орон нутаг хуульд заасан орон нутгийн чиг үүргээ хэрэгжүүлэх тодорхой салбарт үүсгэн байгуулж болно.

8.4.Энэ хуулийн 8.1, 8.3-т зааснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулахыг хориглоно.

8.5.Энэ хуулийн 8.3-т заасан орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах салбарын жагсаалтыг Засгийн газар батална.

9 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах санал гаргах

9.1.Төрийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн гаргана.

9.2.Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг Засаг дарга гаргана.

9.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулахад дараах баримт бичгийг саналд хавсаргана:

9.3.1.энэ хуулийн 9.4-т заасан төлөвлөгөө;
9.3.2.компанийн дүрмийн төсөл;
9.3.3.төрийн өмчит компани бол санхүүгийн төлөвлөгөөний талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс авсан зөвшөөрөл, орон нутгийн өмчит компани бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан зөвшөөрөл;

9.3.4.тухайн компанийн үйл ажиллагаа явуулах чиглэл, салбарын өрсөлдөөн, бизнесийн орчны талаарх Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын санал дүгнэлт.

9.4.Энэ хуулийн 8.1, 8.3-т заасан компанийг үүсгэн байгуулах тохиолдолд дараах асуудлыг тусгасан төлөвлөгөөг гаргана:

9.4.1.компани байгуулах хэрэгцээ, шаардлага, зах зээлийн эрэлт, компаниас гаргах бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх зах зээлийн хүлээлт,

компаниас гаргах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах чадамж, компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх байдлын талаарх зах зээлийн судалгаа, байршил;

9.4.2.бүтээгдэхүүн, үйлчилгээг явуулахад шаардагдах түүхий эд, хангамж, эрчим хүч, ажиллах хүч болон бусад шаардлагатай хүчин зүйлийг хангах эх үүсвэр, чадамж;

9.4.3.хөрөнгө оруулалтын хэмжээ, төрөөс, эсхүл орон нутгаас оруулах эхний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, үлдсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг эргэн төлөх төлөвлөгөө, эргэлтийн хөрөнгө үүсгэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд тавигдах шаардлага;

9.4.4.тухайн компанийг үүсгэн байгуулснаар холбогдох салбарын хөгжлийн төлөвлөгөө, бодлогод нийцсэн байдал, нийгэм, эдийн засгийн үр дүнтэй байдлын талаарх судалгаа;

9.4.5.компанийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа явуулах хугацаа;

9.4.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах арга хэмжээ.

9.5.Энэ хуулийн 8.1, 8.3-т заасан компанийн дүрмийн төслийг боловсруулахдаа төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авна.

10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах шийдвэр гаргах

10.1.Энэ хуулийн 8.1-д заасан компани үүсгэн байгуулах шийдвэрийг гаргахаас өмнө компани байгуулах шаардлагатай эсэхийг Засгийн газрын шийдвэрээр байгуулсан үнэлгээний хороо үнэлэх бөгөөд Засгийн газар уг үнэлгээний хорооны дүгнэлтийг харгалзан холбогдох шийдвэрийг гаргана.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан үнэлгээний хороо нь орон тооны бус байх ба үнэлгээний хорооны ажиллах дүрэм, бүтэц, орон тоог Засгийн газар батална.

10.3.Үнэлгээний хорооны гишүүн нь сүүлийн таван жил төрийн улс төрийн албан тушаал хашиж байгаагүй, улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, төрийн албан хаагч бус, бизнес, хөрөнгө оруулалт, санхүү, хууль эрх зүйн мэдлэгтэй, бизнесийн салбарт удирдах албан тушаал гурваас доошгүй жил ажилласан туршлагатай мэргэшсэн этгээд байна.

10.4.Энэ хуулийн 8.3-т заасан компани үүсгэн байгуулах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах шаардлагатай эсэх талаар орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын дүгнэлтийг харгалзан гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

11 дүгээр зүйл.Хувьцаа олж авах, компанийн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрх

11.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг шинээр үүсгэн байгуулах, төр, эсхүл орон нутаг хувьцааг нь эзэмшдэггүй компанийн хувьцааны хяналтын багцаас доошгүй хувийг олж авах замаар төрийн болон орон нутгийн өмчит компани болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани бий болно.

11.2.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу төрийн өмчит компани байгуулах шийдвэрийг Засгийн газар гаргана.

11.3.Энэ хуулийн 8.1.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий салбарт төрийн өмчит компани шинээр үүсгэн байгуулах, төр хувьцааг нь эзэмшдэггүй компанийн хувьцааны хяналтын багцаас дээш хувийг олж авах, эсхүл төрийн өмчит компанийн хувьцааны хяналтын багцаас доошгүй хувийг худалдах, шилжүүлэх тохиолдолд Улсын Их Хурлын зөвшөөрлийг авсан байна.

11.4.Энэ хуулийн 8.3-т заасны дагуу орон нутгийн өмчит компани байгуулах шийдвэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.

11.5.Дараах тохиолдолд энэ хуулийн 11.1-д заасан хяналтын эрхтэй багцаас доош хэмжээний компанийн хувьцааг олж авч болно:

11.5.1.бэлэглэл, өв залгамжлалаар эзэмшилдээ олж авсан бол;

11.5.2.хууль, Улсын Их Хурлын тогтоолд заасны дагуу;

11.5.3.арилжааны гэрээний дагуу.

11.6.Энэ хуулийн 11.5-д заасны дагуу хувьцааг олж авсан бол төр, эсхүл орон нутаг тухайн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах арга хэмжээг авна.

11.7.Компанийн хувьцааны олонхийн эрхтэй багцыг төр, эсхүл орон нутаг эзэмшсэн бол төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд компанийг үүсгэн байгуулсан зорилгод нийцүүлэн компанийн зорилго, үйл ажиллагааны хүрээг томъёолон компанийн дүрэмд тусгуулна.

11.8.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани дахь төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд компанийн дүрэмд дараах нөхцөлийг тусгуулна:

11.8.1.компанийн жилийн төсвийг бэлтгэхэд суурь болох санхүүгийн төлөвлөгөөг жил бүр гаргах;

11.8.2.компанийн бүх орлого, зарлага нь санхүүгийн төлөвлөгөөтэй нийцсэн төсвийн задаргаагаар тодорхой харагдаж байх;

11.8.3.компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл.

11.9.Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх Компанийн тухай хуулийн 89.4-т заасан бусад тохиолдол төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрэмд хамаарахгүй.

11.10.Шинээр үүсгэн байгуулах, хувьцааг нь эзэмшдэггүй компанийн хувьцааг олж авах замаар компанийг бий болгосон бол төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд компанийн дүрэмд дараах нөхцөлийг тусгуулна:

11.10.1.Компанийн тухай 69.1, 69.4-т заасан хурал хүчин төгөлдөр болох саналын эрхийн хувь хэмжээнээс өндөр хувь тогтоох;

11.10.2.Компанийн тухай хуулийн 63.6-д заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох саналын эрхийн хувь хэмжээнээс өндөр хувь тогтоох;

11.10.3.энэ хуульд нийцүүлэн ногдол ашиг хуваарилах зарчим;

11.10.4.төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдийн шийдвэрээр тогтоосон хууль тогтоомжид нийцсэн бусад шаардлагатай нөхцөл.

11.11.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани охин компани байгуулах, эсхүл төр хувьцааг нь эзэмшдэггүй компанийн хувьцааны хяналтын багцаас доошгүй хувийг олж авах тохиолдолд Засгийн газрын зөвшөөрлийг авсан байна. Засгийн газар энэ хуулийн 10.1-д заасны дагуу үнэлгээний хорооны дүгнэлтийг харгалзан шийдвэр гаргана.

11.12.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани охин компани байгуулах, эсхүл орон нутаг хувьцааг нь эзэмшдэггүй компанийн хувьцааны хяналтын багцаас доошгүй хувийг олж авах тохиолдолд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлийг авсан байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 10.4-т заасны дагуу орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын дүгнэлтийг харгалзан шийдвэр гаргана.

11.13.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар баримтлах төрийн бодлогыг хамтран боловсруулж, Засгийн газраар батлуулна.

11.14.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар баримтлах төрийн бодлого Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5, 6.7, 6.8-д заасан Монгол Улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцсэн байна.

12 дугаар зүйл.Мэдээллээр хангах

12.1.Төрийн өмчийн хувьцааг удирдах этгээд тухайн компанийн харьяалах салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд, орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, хурлын тэмдэглэлийн хуулбар зэрэг төрийн, эсхүл орон нутгийн өмчийн хувьцааг удирдах чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг нь илэрхийлэх баримт, мэдээллийг шилжүүлэх үүрэгтэй.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан баримт бичиг, шийдвэрийн хуулбарыг тухайн шийдвэр гарсан болон хурлын тэмдэглэлд холбогдох этгээд гарын үсэг зурснаас хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.

13 дугаар зүйл.Үнэт цаас гаргах, зээл авах

13.1.Компанийн хувьцааны хяналтын эрхтэй багцыг төр эзэмшдэг бол төрийн өмчийн хувьцааг удирдах этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, компанийн хувьцааны хяналтын эрхтэй багцыг орон нутаг эзэмшдэг бол орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр үнэт цаас гаргах, эсхүл зээл авна.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасны дагуу үнэт цаас гаргахад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн⁴ 10.5-д заасан танилцуулга, мэдээллийг бэлтгэж, холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан зөвшөөрөлд тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл хамаарахгүй.

13.4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа бол төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд давуу эрхийн хувьцаа гаргах хувилбар байж болох эсэхийг судлах үүрэгтэй.

13.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд энэ хуулийн 13.4-т заасан үүргээ биелүүлэхдээ өөрийн эзэмшиж байгаа хувьцааны хэмжээг харгалзан хувьцаа эзэмшигчдийн эрхийн тэнцвэргүй байдал бий болохоос зайлсхийх үүрэгтэй.

14 дүгээр зүйл.Ногдол ашиг

14.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд доор дурдсан зарчмын дагуу ногдол ашиг хуваарилна:

14.1.1.өмнөх жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаар гарсан татварын дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

14.1.2.төрийн болон орон нутгийн эзэмшлийн эздийн өмчийн тодорхой хувиар.

⁴Үнэт цаасны зах зээлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

14.2.Төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдээс төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн нийт дүнгийн доод хэмжээг Улсын Их Хурлаас жил бүрийн төсөвт тусган батална.

14.3.Тухайн төсвийн жилд баримтлах энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан хувийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Улсын Их Хурал, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсөвтэй хамт батална.

14.4.Төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан зарчмын дагуу энэ хуулийн 14.3-т заасны дагуу тогтоосон хувиар тооцсон дүнгийн аль өндөр дүнгээр төсөвт ногдол ашиг төвлөрүүлнэ.

14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 14.1, 14.2, 14.3, 14.4-т заасныг баримтлан ногдол ашгийн дүнг тооцсоныг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх Засгийн газрын чиглэл гэж үзнэ.

14.6.Төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар өгсөн энэ хуулийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд тайлагнах үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

15 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

15.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

15.1.1.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

15.1.2.компанийн үйл ажиллагаа хамаарах салбарын болон санхүүгийн мэдлэг, туршлагатай, тухайн салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, хууль, санхүү, бизнесийн удирдлага, эдийн засгийн дээд боловсролтой;

15.1.3.нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, компанийн зорилго, ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах чадвартай;

15.1.4.сүүлийн найман жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй;

15.1.5.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

15.1.6.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

15.1.7.Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан байх;

15.1.8.Доор дурдсан ашиг сонирхлын зөрчилтэй этгээд биш байх:

15.1.8.а.компанитай адил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа, тухайн компанийн хувьцаа эзэмшигч биш хувиараа аж ахуй эрхлэгч, нөхөрлөлийн гишүүн, эсхүл тухайн компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч;

15.1.8.б.компанитай адил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа, тухайн компанийн хувьцаа эзэмшигч биш компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

15.1.8.в.компанийн ажил, үйлчилгээг хүлээн авах, бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, эсхүл тус компанид ажил, үйлчилгээ үзүүлэх, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах зэрэг байдлаар компанитай харилцах замаар их хэмжээний хэлцэл байгуулсан аливаа этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн.

15.1.8.г.компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээдийн удирдах албан тушаалтантай хамаарал бүхий, эсхүл нэгдмэл сонирхолтой.

15.2.Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр нь ажилладаг компани төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани бол энэ хуулийн 15.1.8.б-д заасан хамаарахгүй.

15.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес, түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс дээшгүй хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн албан тушаалтныг нэр дэвшүүлэх, сонгохыг хориглоно.

15.4.Жижиг, дунд хэмжээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл таваас илүүгүй гишүүнтэй байх ба тэдгээрийн 2 хүртэлх гишүүн нь төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн албан тушаалтныг нэр дэвшүүлэх, сонгохыг хориглоно.

15.5.Жижиг, дунд хэмжээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр бүх гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

15.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг хангаагүй этгээдийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, томилуулахаар нэр дэвшүүлэх, эсхүл дэмжиж санал өгөхийг хориглоно.

16 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх хороо

16.1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох зорилгоор төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшүүлэх хороог байгуулна.

16.2.Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь төрийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тухайн компанийн дараах албан тушаал, асуудлаар хэрхэн санал гаргахыг тодорхойлоход оршино:

16.2.1.төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийг сонгох, албан тушаалаас чөлөөлөх;

16.2.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацааг тогтоох;

16.2.3.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ.

16.3.Нэр дэвшүүлэх хорооны гишүүд энэ хуулийн 16.2-т заасан саналыг тодорхойлохдоо энэ хуулийн 15.1, 15.2-т заасан шаардлагад нийцүүлнэ.

16.4.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим тус бүрээс үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сүүлийн таван жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа магадлан итгэмжлэгдсэн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, Санхүүгийн зохицуулах хороо, Авилгатай тэмцэх газар тус бүрээс ил тод байдал, компанийн сайн засаглалын чиглэлээр сүүлийн таван жилд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа нийтэд үйлчлэх зорилготой магадлан итгэмжлэгдсэн ашгийн төлөө бус хуулийн этгээлийг санал болгох ба эдгээр дөрвөн байгууллага тус бүр энэ хуулийн 16.1-д заасан нэр дэвшүүлэх хороонд нэг гишүүнийг санал болгоно.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан нэр дэвшүүлэх хорооны гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

16.5.1.тухайн бизнесийн салбарт мэргэшсэн, удирдах ажлын туршлагатай, олон нийтэд нэр хүндтэй;

16.5.2.сүүлийн гурван жилд нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажиллаагүй;

16.5.3.төрийн өмчийн хувьцааг удирдах этгээдтэй ашиг сонирхлын зөрчилгүй;

16.5.4.улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй; 16.5.5.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд⁵ заасан журмын дагуу холбогдох мэдүүлгийг гаргаж өгсөн байх.

16.6.Энэ хуулийн 16.4-т заасан гишүүнийг гурван жилийн хугацаагаар томилно.

16.7.Энэ хуулийн 16.1-д заасан нэр дэвшүүлэх хороонд энэ хуулийн 16.4-т зааснаас гадна дараах албан тушаалтан нэр дэвшүүлэх хорооны гишүүн байна:

16.7.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

16.7.2.хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

16.7.3.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нь нэр дэвшүүлэхээр хэлэлцэж байгаа компанийн хувьцааг нь удирдах төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

16.7.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага хувьцааг нь удирддаг компанийн асуудлыг хэлэлцэж байгаа бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга.

16.8.Нэр дэвшүүлэх хорооны даргыг энэ хуулийн 16.4-т заасан гишүүд дундаасаа сонгоно.

16.9.Нэр дэвшүүлэх хороо дараах эрхийг эдэлнэ:

16.9.1.нэр дэвшүүлэх хороо хуралдах, хэлэлцэх асуудлын жагсаалт гаргах, холбогдох баримт бичгийг бэлтгэж гишүүдэд танилцуулах, шийдвэр гаргах асуудлаар холбогдох журмыг батлах;

16.9.2.компанийн зорилго, онцлог, эрхлэх үйл ажиллагааг харгалзан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах этгээдэд олговол зохих эрх мэдлийн асуудлаар судалгаа хийж, тайлан гаргах;

⁵Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

16.9.3.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвших этгээд ашиг сонирхлын зөрчилтэй, эсхүл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх болон бусад асуудлаар үнэлэлт, дүгнэлт өгөх;

16.9.4.шаардлагатай тохиолдолд ашгийн төлөө бус хуулийн этгээд, холбогдох салбарын мэргэшсэн этгээд болон бусад этгээдийг үнэлэлт, дүгнэлт өгөх, судалгаа хийж тайлан гаргах ажилд татан оролцуулах.

16.10.Хэрэв энэ хуулийн 16.4-т заасан этгээд эрүүл мэндийн болон бусад шалтгааны улмаас удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно.

16.11.Нэр дэвшүүлэх хорооны гишүүн хорооны хуралд оролцсоны төлөө зохих хөлс, урамшуулал авч болох ба хуралд оролцсоны улмаас гарсан зардлаа нөхөн төлүүлэх эрхтэй.

17 дугаар зүйл.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх хороо

17.1.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг санал болгох зорилгоор орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшүүлэх хороог байгуулна.

17.2.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим тус бүрээс үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сүүлийн таван жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа, магадлан итгэмжлэгдсэн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, Санхүүгийн зохицуулах хороо, Авилгатай тэмцэх газар тус бүрээс ил тод байдал, компанийн сайн засаглалын чиглэлээр сүүлийн таван жилд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа нийтэд үйлчлэх зорилготой магадлан итгэмжлэгдсэн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг санал болгох ба эдгээр дөрвөн төрийн бус байгууллага тус бүр нэр дэвшүүлэх хорооны гишүүнд нэг хүнийг санал болгоно.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан нэр дэвшүүлэх хороонд энэ хуулийн 16.2, 16.3-16.9-д заасан нэгэн адил хамаарна.

18 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээс шаардах мэдээлэл

18.1.Нэр дэвшүүлэх хороо төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана.

18.2.Энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд зарласнаас хойш 30 хоногийн дотор дараах

мэдээллийг нотолсон баримт бичгийг бүрдүүлэн нэр дэвшүүлэх хороонд нэр дэвших тухай хүсэлтээ хүргүүлсэн байна:

18.2.1.эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, боловсролын байдлын талаарх баримт бичиг, холбоо барих мэдээлэл;

18.2.2.сүүлийн таван жилийн ажил эрхлэлт, хувийн эрх зүйн хуулийн этгээдэд эрх бүхий албан тушаал эрхэлж байсан эсэх зэрэг мэдээллийг агуулсан ажлын туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

18.2.3.нэр дэвшигч болон түүний холбогдох этгээдийн хувьцааг нь эзэмшдэг компанийн нэр хаяг, улсын бүртгэлийн дугаар, сүүлийн таван санхүүгийн жилд үйл ажиллагаа эрхэлсэн салбарын жагсаалт, ашгийн хэмжээ, эзэмшиж байгаа хувьцааны хэмжээ зэрэг мэдээлэл.

18.3.Нэр дэвшүүлэх хороо төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагааг хариуцан авна.

19 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох

19.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааны хэмжээтэй хувь тэнцүү тооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх санал гаргах эрхтэй.

19.2.Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд нэр дэвшүүлэх хорооны саналд үндэслэн зохих санал, шийдвэрийг гаргана:

19.2.1.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх;

19.2.2.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний тоо, бүрэн эрхийн хугацааг тогтоох;

19.2.3.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох.

19.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг энэ хуулийн 15.1-д заасан шаардлага хангаагүй гэх үндэслэлээр эс зөвшөөрсөн бол нэр дэвшүүлэх хороо 15 хоногийн дотор дахин санал гаргах үүрэгтэй.

19.4.Энэ хуулийн 19.3-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилогдоогүйн улмаас компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж компанид болон хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.

19.5.Нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон нэр дэвшигчийг төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд энэ хуулийн 15.1-д заасан шаардлага хангасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухайд томилох, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухайд томилуулахаар нэр дэвшүүлнэ.

19.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд жендэрийн эрх тэгш байдал буюу төлөөлөн удирдах зөвлөл дэх хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилно.

19.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жилээс хэтрэхгүй бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

20 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг, хариуцлага

20.1.Энэ хуулийн 19.5-д заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд түүнийг томилсон, эсхүл томилуулахаар санал болгосон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд дараах мэдээллийг өгөх үүрэгтэй.

20.1.1.компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үл хамаарах, их хэмжээний, эсхүл эрх зүйн өндөр ач холбогдолтой хэлцлийг хийх тухай аливаа төлөвлөгөө;

20.1.2.гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээлэл;

20.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тогтоосон хугацаанд, түүнээс баталсан загварын дагуу бэлтгэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл;

20.1.4.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаарх аливаа мэдээлэл.

20.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилогдсон этгээд түүнийг томилсон, эсхүл томилуулахаар санал болгосон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд дараах мэдээллийг өгөх үүрэгтэй:

20.2.1.төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш нэг сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудалтай холбоотой тараасан баримт бичиг, хурлын тэмдэглэлийн хуулбар, хурлаас гарсан шийдвэр;

20.2.2.төлөөлөн удирдах зөвлөл хуралдахгүйгээр шийдвэр гаргасан бол шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан тухайн үеийн байдлаар

болон санал өгсөн тухай мэдээлэл, санал хураалтын дүнг санал хураалт болсноос хойш ажлын 5 өдрийн дотор.

20.3.Энэ хуулийн 19.5-д заасны дагуу төр болон орон нутаг хяналтын багцыг эзэмшдэггүй компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд түүнийг томилсон, эсхүл томилуулахаар санал болгосон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй ажлын өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал хуралдсанаас хойш гурван сарын дотор хурлын тэмдэглэлийг хүргүүлнэ.

20.4.Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлд нэгээс дээш гишүүн томилогдсон бол төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд энэ хуулийн 21.1-д заасан мэдээлэл ирүүлэх нэг гишүүнийг түүний саналыг харгалзан томилно.

20.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд дараах үүрэгтэй:

20.5.1.эрх, үүргээ үнэнч шударгаар, компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх;

20.5.2.эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай цаг зарцуулж, төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд тогтмол оролцох;

20.5.3.шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцах, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;

20.5.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

20.5.5.өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх.

20.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн бол төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд уг зөрчлийн тухай нотлох баримтын хамт бичгээр мэдэгдэл хүргүүлж, холбогдох арга хэмжээ авна.

20.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрэмд тусгасан байна.

21 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлаас чөлөөлөл

21.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг ажлаас нь чөлөөлнө:

21.1.1.энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;

21.1.2.хууль, компанийн дүрэмд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, үүргээ ноцтой, удаа дараа зөрчсөн, компанийг зохистой удирдах шаардлагыг хангахгүй болсон;

21.1.3.хууль, компанийн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэл хийсэн;

21.1.4.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

21.1.5.эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлээгүй, албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;

21.1.6.эрх бүхий байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;

21.1.7.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

21.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь энэ хуулийн 21.1.2, 21.1.3, 21.1.4-т заасан үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

22 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшуулал

22.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд компанийн дүрэмд дараах нөхцөлийг тусгуулна:

22.1.1.төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын хэмжээ, урамшуулал төлөх журмыг компанийн онцлог нөхцөл байдлыг харгалзан төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд дангаараа тогтооно;

22.1.2.хувьцааных нь хяналтын багцыг төр, эсхүл орон нутаг эзэмшдэг боловч бүх хувьцааг нь дангаараа эзэмшдэггүй бол уг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын хэмжээ, урамшуулал төлөх журмыг компанийн онцлог нөхцөл байдлыг харгалзан хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

22.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн урамшууллын хэмжээ тэгш байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь аудитын хороо болон төлөөлөн удирдах зөвлөлийн бусад хороонд ажилласан бол нэмэгдэл хөлс авч болно.

22.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно.

22.4.Энэ хуулийн 22.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол хөлс, урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс төлөөлөн удирдах зөвлөлийн даргын урамшууллыг төлөхийг түдгэлзүүлэх, эсхүл үүрэг биелүүлээгүй тухайн хугацаанд хамаарах хувь хэмжээгээр урамшууллын хэмжээг бууруулж болно.

22.5.Энэ хуулийн 22.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол хөлс, урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллыг төлөхийг түдгэлзүүлэх, эсхүл үүрэг биелүүлээгүй тухайн хугацаанд хамаарах хувь хэмжээгээр урамшууллын хэмжээг бууруулж болно.

22.6.Энэ хуулийн 22.4, 22.5-д заасны дагуу урамшуулал төлөхийг түдгэлзүүлэх, эсхүл бууруулах арга хэмжээг хөлс, урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс компанийн гүйцэтгэх удирдлагад хандан төлөөлөн удирдах зөвлөлийн даргад энэ тухай бичгээр гаргасан мэдэгдэлд үндэслэж авна.

23 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлага, түүнийг хэрэгжүүлэх этгээдэд нэр дэвшигчид тавигдах шаардлага

23.1.Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх этгээдийг төлөөлөн удирдах зөвлөл сонгож, гэрээ байгуулан ажиллуулна.

23.2.Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх этгээдэд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

23.2.1.энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг хангасан байх;

23.2.2.бизнесийн удирдлага болон компанийн үйл ажиллагаа хамаарах салбарын мэдлэг, туршлагатай байх;

23.2.3.өмнө нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал, гүйцэтгэх захирал, дэд захирлын албан тушаалаас өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас чөлөөлөгдөж байгаагүй;

23.2.4.бусад компанийн гүйцэтгэх удирдлагын албан тушаал эрхлээгүй байх;

23.2.5.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.

23.3.Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, сонгох журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

23.4.Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд гүйцэтгэх удирдлагын ажлын зорилт, зорилго, хүлээгдэж байгаа үр дүн, урамшууллын хэмжээ, түүнийг олгох журам, эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлага, түүний эрх хэмжээг түдгэлзүүлэх, чөлөөлөх үндэслэл, журам болон үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээ, мэдээллийг гаргах хуваарийн талаар тодорхой тусгасан байна.

23.5.Энэ хуулийн 23.2-т заасан шаардлагыг хангаагүй этгээдийг гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх этгээдэд нэр дэвшүүлэх, сонгохыг хориглоно.

24 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлагын цалин, нэмэгдэл урамшуулал

24.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд төр, эсхүл орон нутаг хяналтын багцыг нь эзэмшдэг компанийн дүрэмд дараах нөхцөлийг тусгуулна:

24.1.1.гүйцэтгэх удирдлагын гишүүнд олгох цалин хөлсний хэмжээг гагцхүү түүнтэй байгуулсан гэрээнд заасны дагуу олгоно. Гүйцэтгэх удирдлагын гишүүн гэрээнд зааснаас гадна чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч тухайн чиг үүрэгт тохирсон нэмэгдэл урамшууллыг олгохоор гэрээнд заагаагүй бол аливаа урамшуулал олгохгүй;

24.1.2.гүйцэтгэх удирдлагын нэмэлтээр гүйцэтгэсэн гэх чиг үүргийн үр дүнд компанийн зорилгод нийцсэн нэмүү өртөг бий болсон, компанийн зах зээлд эзлэх байр суурь өсөн нэмэгдсэн бол нэмэгдэл урамшуулал олгохоор гэрээнд зааж болно;

24.1.3.тухайн жилд гүйцэтгэх удирдлагын гишүүнд олгох нийт нэмэгдэл урамшууллын хэмжээ өмнөх санхүүгийн жилийн тухайн гишүүнд олгосон нэг сарын дундаж үндсэн цалинг дөрөв дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байх;

24.1.4.гүйцэтгэх удирдлагын гишүүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусгавар болохоос өмнө төлөөлөн удирдах зөвлөлийн санаачилгаар чөлөөлөхөөр шийдвэрлэсэн бол түүнд нөхөн төлбөр, олговрын хэлбэр бүхий тэтгэмж өгч болно. Тэтгэмжийн хэмжээ гүйцэтгэх удирдлагын гишүүний гурав хүртэл сарын цалин хөлсөөс хэтрэхгүй байна.

25 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагын үүрэг

25.1. Гүйцэтгэх удирдлага дараах үүрэгтэй:

25.5.1.эрх, үүргээ үнэнч шударгаар, компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх;

25.5.2.компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг шуурхай авах;

25.5.3.үйл ажиллагаандаа компанийн хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлоос гадна оролцогч бусад талууд болох зээлдүүлэгч, бизнесийн түнш, ажилчдын ашиг сонирхолыг харгалзан ажиллах;

25.5.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглахгүй байх;

25.5.5.компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

25.5.5.аудитын хороог чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх;

25.5.6.компанийн санхүүгийн үзүүлэлтийг жил бүр сайжруулах, өр авлага барагдуулах;

25.5.7.санхүүгийн тайланг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.7-д заасан журмыг баримтлан бэлтгэж, ил тод тайлагнах.

25.6. Гүйцэтгэх удирдлага хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн бол төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд уг зөрчлийн тухай нотлох баримтын хамт бичгээр мэдэгдэл хүргүүлж, холбогдох арга хэмжээ авна.

26 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагыг ажлаас чөлөөлөх

26.1. Дараах тохиолдолд гүйцэтгэх удирдлагыг ажлаас нь чөлөөлж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална:

26.1.1. үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд компанийг хоёр жил дараалан алдагдал хүлээлгэсэн, эсхүл төрөөс оруулсан хөрөнгө оруулалт, ашгийн харьцааг хоёр жил дараалан хангаж чадахгүй болсон;

26.1.2. компани төлбөрийн чадваргүй болсон боловч энэ талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдээгүй, дампуурлын өргөдөл гаргаагүй;

26.1.3. энэ хууль, компанийн дүрэм, гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ноцтой зөрчсөн;

26.1.4. компанийн санхүүгийн байдлын талаар худал мэдээлэл өгсөн;

26.1.5. хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдсон;

26.1.6. энэ хуулийн 23.2-т заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;

26.1.7. компанийн шинэ бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратеги бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, туршлага, чадвар хангалтгүй байх;

26.1.8. эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлээгүй, албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;

26.1.9.эрх бүхий байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;

26.1.10.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

26.2.Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 26.1-д заасан үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

26.3.Гүйцэтгэх удирдлагын буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрэмд тусгасан байна.

26.4.Энэ хуулийн 26.1.1-д заасан тохиолдол хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэх боломжгүй, төрөөс нийтийн хэрэгцээг хангах зайлшгүй шаардлагатай салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон орон нутгийн өмчит компанид хамаарахгүй байж болно.

27 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тусгай зохицуулалт

27.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрэмд дараах нөхцөлийг тусгуулна:

27.1.1.хувьцааных нь хяналтын багцыг төр, эсхүл орон нутаг эзэмшдэг төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрмээр Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хязгаарлахгүй байх;

27.1.2.хувьцааных нь хяналтын багцыг төр, эсхүл орон нутаг эзэмшдэг төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

27.1.3.энэ хуулийн 27.1.1-д заасан компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний тоог тогтоохдоо компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тэдний чөлөөт цагт хэрэгжүүлэх үндсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг хангахын сацуу компанийн санхүүгийн байдал, хэмжээг харгалзах;

27.1.4.энэ хуулийн 27.1.1-д заасан компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн байдал, хэмжээг харгалзан гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх;

27.1.5.энэ хуулийн 27.1.1-д заасан компани бусад компанийн хувьцааны хяналтын багцыг олж авах, шилжүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцэх ба охин компани нь бусад компанийн хувьцааны хяналтын багцыг олж авах, шилжүүлэх асуудлыг толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх;

27.1.6.энэ хуулийн 27.1.1-д заасан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар охин компанийн баримтлах удирдлагын болон тайлагналын зарчмыг батлах;

27.1.7.энэ хуулийн 27.1.1-д заасан компанийн охин компани холбогдох асуудлаар шийдвэр гаргахдаа толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийг авахаар энэ хуулийн 24.1.1-д заасан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн бол холбогдох этгээдийн зөвшөөрлийг авах;

27.1.8.энэ хуулийн 27.1.1-д заасан компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах;

27.1.9.энэ хуулийн 20.1, 20.2-т заасан мэдээллийн хэлбэр, агуулгын талаар харьяалах төрийн захиргааны төв байгууллагаас тодорхой загвар гаргасан бол мэдээллийг тус загварын дагуу гаргаж хүргүүлэх;

27.1.10.энэ хуулийн 27.1.1-д заасан компанийн төрөөс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурлын тэмдэглэлтэй танилцах эрхийг хангах;

27.1.11.энэ хуулийн 27.1.1-д заасан компани нь удирдлагын үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалын зарчмыг мөрдөж ажиллах, компанийн сайн засаглалын зарчмыг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг жил бүр үйл ажиллагааны тайландаа тусгах;

27.1.12.энэ хуулийн 27.1.1-д заасан компани нь компанийн эрхлэх үйл ажиллагааны салбарт хамаарах бүтээгдэхүүний хөгжүүлэлт, судалгааны үр дүнг компанийн үйл ажиллагаа, санхүүгийн зорилгоор ашиглахаар судалгаа хийлгэхэд зориулж бэлэг, хандив, тэтгэлэг өгч болох ба энэ тохиолдолд компанийн дүрэмд бэлэг, хандив, тэтгэлгийн хэмжээ, болзол, нөхцөл, тухайн санхүүгийн жилд өгөх бэлэг, хандив, тэтгэлгийн дээд хэмжээ, шийдвэр гаргах нарийвчилсан журам.

27.2.Энэ хуулийн 27.1.12-т заасан журамд дараах нөхцөлийг тусгасан байна:

27.2.1.тухайн санхүүгийн жилд олгох нийт бэлэг, хандив, тэтгэлгийн хэмжээ нь төр хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компани, түүний нэгдэлд хамаарах охин компанийн санхүүгийн сүүлийн гурван жилд нийт олсон ашгийн дунджийн 0.5 хувиас хэтрэхгүй байх;

27.2.2.бэлэг, хандив, тэтгэлэг өгсөн тухай мэдээллийг холбогдох шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор компанийн цахим хуудсанд байршуулах бөгөөд тус мэдээлэл нь таван жилээс доошгүй хугацаанд нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулах;

27.2.3.бэлэг, хандив, тэтгэлгийг хүлээн авагчийн нэр, бэлэг, хандив, тэтгэлгийн хэмжээ, тэдгээрийг өгсөн зориулалт, ийнхүү бэлэг, хандив,

тэтгэлэг олгох нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн зорилгод хэрхэн хамаарч байгаа талаарх үндэслэлийг цахим хуудсанд нээлттэй байршуулсан мэдээлэлд тодорхой тусгасан байх.

27.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл, төр, эсхүл орон нутгийн оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ, ашиг, алдагдал, өр, технологи, үйлдвэрийн шинэчлэл, бэлэг, хандив, тэтгэлэг, ногдол ашиг, удирдлагын цалин урамшуулал, их хэмжээний хэлцэл, жилийн санхүүгийн тайлан нийтэд ил тод байх бөгөөд тус мэдээлэл нь таван жилээс доошгүй хугацаанд нийтэд нээлттэй байна.

ТАВДУГААР БҮЛЭГ КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

28 дугаар зүйл.Компанийн дотоод хяналт, дотоод аудит

28.1.Хувьцааных нь хяналтын багцыг төр, эсхүл орон нутаг эзэмшдэг бол компани дотоод хяналтын тогтолцоог бий болгох үүрэгтэй.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан компани дараах гурван үзүүлэлтийн хоёроос доошгүйг нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр хангаж байвал дотоод аудиторын тогтолцоог бий болгоно:

28.2.1.нийт ашгийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс доошгүй байх;

28.2.2.борлуулалтын орлогын хэмжээ 2 тэрбум төгрөгөөс доошгүй байх;

28.1.2.3.нийт ажилтны тоо 75-аас доошгүй байх.

28.3.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл энэ хуулийн 28.1-д заасан компанийг дотоод аудиторын тогтолцоотой байх нь эдийн засгийн хувьд оновчтой гэж үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын зөвшөөрлөөр энэ тухай шийдвэр гаргаж болно.

29 дүгээр зүйл.Компанийн дотоод хяналтын тогтолцоо

29.1.Компанийн дотоод хяналтын нэгж нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээлэл үнэн зөв эсэхийг хянан шалгаж, дүгнэлт өгөх, компанийн үйл ажиллагааг компанийн хэтийн зорилго, бизнес төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай үр ашигтай уялдуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

29.2.Компанийн дотоод хяналтын нэгж компанийн үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засгийн үр ашгаас шалтгаалан төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тооны бүтцэд хамаарах 3 хүртэлх тооны хянан шалгагчаас бүрдэнэ.

29.3.Компанийн дотоод хяналтын нэгж компанийн бүх нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж дүгнэлт гаргах ба дүгнэлтээ гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

29.4.Компанийн дотоод хяналтын нэгжийн хянан шалгагч компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтны албан өрөөнд нэвтрэн орох, компанийн данс бүртгэл, тайлан тэнцэл, санхүүгийн баримт, тайлбар, лавлагаа болон шаардлагатай бусад баримт бичгийг холбогдох албан тушаалтнаас гаргуулж авах эрхтэй.

29.5.Компанийн дотоод хяналтын нэгжийн хянан шалгагчийн бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг энэ хуульд нийцүүлэн компанийн дүрмээр тогтооно.

30 дугаар зүйл.Компанийн дотоод аудитын тогтолцоо

30.1.Энэ хуулийн 28.2-т заасан компани нь төлөөлөн удирдах зөвлөлийнхөө дэргэд Компанийн тухай хуулийн 81.4-т заасан дүгнэлт гаргах үүрэг бүхий аудитын хороог байгуулна.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан аудитын хороо нь компанийн хэтийн болон ойрын зорилго, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланг хянан шалгаж алдаа дутагдал бий эсэх, хэрхэн залруулах арга зам, шийдлийг тодорхойлсон дүгнэлт гарган төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажиллана.

30.3.Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИ, ТҮҮНИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

31 дүгээр зүйл.Гүйцэтгэх удирдлагын менежментийн төлөвлөгөө

31.1.Гүйцэтгэх удирдлага нь гэрээ байгуулснаас хойш 3 сарын хугацаанд таваас доошгүй жилийн хугацаатай компанийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.

31.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж баталсан менежментийн төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

31.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд компанийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар

баримтлах төрийн бодлого, чиглэлийг харгалзан менежментийн төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулахыг гүйцэтгэх удирдлагад даалгаж болно.

31.3.Менежментийн төлөвлөгөөнд оруулсан аливаа өөрчлөлтийг энэ хуулийн 31.1, 31.2-т заасан журмын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

32 дугаар зүйл.Менежментийн гүйцэтгэлийн тайлан

32.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани менежментийн гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр бэлтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд хүргүүлнэ.

32.2.Менежментийн гүйцэтгэлийн тайланг санхүүгийн жил дууссаны дараагийн жилээс эхлэн жил бүр гаргах бөгөөд жилийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

33 дугаар зүйл.Менежментийн гүйцэтгэлийн үнэлгээ

33.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэлийг компанийн менежментийн гүйцэтгэлийн үр дүнгээр тооцон үнэлнэ.

33.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан менежментийн гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчит компанийн менежментийн гүйцэтгэлийг үнэлнэ.

33.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага компанийн менежментийн гүйцэтгэлийн үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг хүргүүлэхийг шаардах эрхтэй.

33.4.Менежментийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, аргачлал, үнэлгээний журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар батална.

33.5.Энэ хуулийн 33.4-т заасан үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:

33.5.1.менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин;

33.5.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн зохистой менежмент;

33.5.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт;

33.5.4.гүйцэтгэлд суурилсан төлбөрийн тогтолцоо.

33.6.Менежментийн гүйцэтгэлийг үнэлэхдээ төрийн болон орон нутгийн өмчит компанитай ижил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бусад компанийн гүйцэтгэлтэй харьцуулж болно.

33.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага компанийн менежментийн гүйцэтгэлийн үнэлгээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусгаж, үнэлгээний тайланг Засгийн газар болон компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдэд танилцуулна.

33.8.Компанийн менежментийн гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэх удирдлагыг чөлөөлүүлэхээр санал гаргах эрхтэй.

33.9.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудитор, компанийн бусад эрх бүхий албан тушаалтан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол албан тушаалаас чөлөөлүүлэхээр санал гаргах эрхтэй.

34 дүгээр зүйл.Арга хэмжээ

34.1.Энэ хуулийн 26.4-т зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компани хоёр жил дараалан санхүүгийн зорилтот үр дүнд хүрээгүй ажилласан бол өрийг хувьцаагаар солих, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, эсхүл хувьчлах арга хэмжээ авна.

35 дугаар зүйл.Алтан хувьцаа

35.1.Засгийн газар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд энэ хуулийн 35.2-т заасан асуудлаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй алтан хувьцааг гаргахаар зааж болно.

35.2.Алтан хувьцаатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагаас дараах асуудлаар гаргасан шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрх ашигт харшилсан тохиолдолд Засгийн газар хориг тавина:

35.2.1.компанийн нэр, ерөнхий захиргаа оршин байгаа газрын хаягийг өөрчлөх;

35.2.2.хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;

35.2.3.алтан хувьцаа эзэмшигчийн эрхийг өөрчилсөн дүрэм, журам батлах;

35.2.4.хувьцаа эзэмшигчийн эрхийг өөрчилсөн дүрэм, журам батлах;

35.2.5.компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

35.2.6.их хэмжээний хэлцэл байгуулах;
35.2.7.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох, өөрчлөх.

35.3.Засгийн газар энэ хуулийн 35.2-т заасны дагуу хориг тавих тухай шийдвэртээ хориг тавьж байгаа үндэслэлээ заана.

35.4.Энэ хуулийн 35.2-т заасан асуудлаар компанийн гаргасан шийдвэр Засгийн газрын батламжилснаар хүчин төгөлдөр болно.

35.5.Алтан хувьцааг бусдад шилжүүлэхийг хориглоно.

35.6.Энэ хуулийн 35.1-д заасан тодорхой хугацаа дуусмагц алтан хувьцаа нь хүчингүй болох бөгөөд хугацааг дахин сунгахгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ИЛ ТОД БАЙДАЛ, НИЙТЭД ТАЙЛАГНАХ

36 дугаар зүйл. Санхүүгийн жил, санхүүгийн тайлан, бүртгэл

36.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль⁶ болон Компанийн тухай хууль⁷ заасан журмын дагуу хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан гаргана.

36.2.Төрийн болон орон нутгийн өмчит компани жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 03 дугаар сарын 31-ний дотор аудитын байгууллагаар баталгаажуулна.

36.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани хагас жилийн санхүүгийн тайлангаа 07 дугаар сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан тайланг тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй салбар, цар хүрээнээс хамаарч аудитаар баталгаажуулах эсэхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

36.5.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор тайлангаа аудитын дүгнэлтийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

36.6.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор тайлангаа аудитын дүгнэлтийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

⁶Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2015 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

⁷Компанийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

байгууллага, орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

36.7.Энэ хуулийн 36.2-т заасан тайланд тухайн санхүүгийн жилийн турш төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэрхэн чиглүүлсэн, удирдан зохицуулсан, хянаж нийцүүлсэн талаарх тайлан, гүйцэтгэх удирдлагын болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хүлээн авсан цалин, урамшууллын хэмжээний талаарх мэдээллийг хавсарган ирүүлнэ.

36.8.Компанийн бусад хувьцаа эзэмшигчид энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан тайлан, мэдээллийг хүлээн авч танилцах эрхтэй.

36.9.Энэ хуулийн 36.1-д заасан үйл ажиллагааны тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна:

36.9.1.санхүүгийн болон санхүүгийн бус зорилтуудын хэрэгжилт, батлагдсан ногдол ашгийн бодлого, үйл ажиллагааны зорилго, зорилтын нийцэл;

36.9.2.бизнесийн стратегийн бодлого, зах зээлийн дүн шинжилгээ;
36.9.3.гадаад болон дотоод зах зээлийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

36.9.4.ирээдүй хэтийн төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой санхүүгийн бус эрсдэл, тодорхой бус хүчин зүйлсийн тайлбар;

36.9.5.санхүүгийн жилийн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалт, онцлох үйл явдал;

36.9.6.төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, цалин хөлс, урамшууллын мэдээлэл;

36.9.7.компанийн тогтвортой байдал болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тайлан.

36.10.Засгийн газар энэ хуулийн 36.9-д заасан үйл ажиллагааны тайлангийн загвар болон тайлан гаргах, хүргүүлэх журмыг батална.

36.11.Энэ хуулийн 36.1-д заасан санхүүгийн тайланг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.7-д заасан журмыг баримтлан бэлтгэнэ.

36.12.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина.

36.13.Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүр төр, эсхүл орон нутаг эдгээр хувьцааг эзэмших зорилго, хувьцааны удирдлагын талаар илтгэл хүргүүлнэ.

36.14.Энэ хуулийн 36.13-т заасан илтгэлийг энэ хуулийн 36.2-т заасан хугацаа дууссанаас хойш 15 хоногийн дотор бичиж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухайд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухайд орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн хянуулна.

36.15.Энэ хуулийн 36.14-т заасны дагуу хянасан илтгэлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 15 хоногийн дотор хүргүүлнэ.

36.16.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага танилцсан илтгэлээ олон нийтэд нээлттэйгээр өөрийн цахим хуудас болон энэ хуулийн 39.4-т заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдсэн цахим хуудсанд байршуулна.

36.17.Засгийн газар энэ хуулийн 36.13-т заасан илтгэлийг бичих, хүргүүлэх тухай журам, агуулгыг тусгасан загварыг батална.

36.18.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани Өрийн удирдлагын тухай хуулийн 6.2.2-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр өөрийн хөрөнгийн 25 хувь буюу түүнээс дээш хэмжээний өр төлбөр үүсгэж болно.

36.19.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн нэгээс илүү жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

36.20.Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг тухайн жилийн төсөвт бүрэн тусгаж, өрийг төлж барагдуулах төлөвлөгөө, хуваарийг баталж хэрэгжүүлнэ.

37 дугаар зүйл.Компанийн нөөц сан

37.1.Төрийн өмчит компани жил бүр татварын дараах цэвэр ашгийн 10 хувиас багагүй хэмжээний хөрөнгийг ногдол ашиг хуваарилахаас өмнө компанийн нөөц санд төвлөрүүлнэ.

37.2.Компанийн нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

37.2.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийг шинэчлэх;

37.2.2.компанийн алдагдлыг нөхөх;

37.2.3.компанийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөнд хамаарахгүй учирч болох эрсдэлийг бууруулах;

37.2.4.компанийн дүрэмд заасан бусад.

37.3.Компанийн нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн нийт хэмжээ нь тухайн компанийн хувь нийүүлсэн хөрөнгийн 50 хувиас хэтэрсэн тохиолдолд компани нөөц санд хөрөнгө төвлөрүүлэхгүй байж болно.

38 дугаар зүйл.Нэгдсэн тайлан

38.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жилд нэг удаа энэ хуулийн 36.2, 36.3, 36.4, 36.5, 36.9-д заасан илтгэл, тайлан, мэдээллийн үндсэн дээр, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн эзэмшиж байгаа хувьцааг шилжүүлэх үр дүнтэй хувилбарын талаарх санал дэвшүүлэн нэгдсэн тайлан гаргаж, Засгийн газарт хүргүүлнэ.

38.2.Засгийн газар энэ хуулийн 38.1-д заасан тайланг батлан Улсын Их Хуралд танилцуулна. Нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудас болон энэ хуулийн 39.4-т заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдсэн цахим хуудсанд олон нийтэд нээлттэйгээр байршуулна.

39 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийг нийтэд мэдээлэх

39.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулж, нийтэд мэдээлэх үүрэгтэй.

39.2.Төрийн болон орон нутгийн өмчит компани энэ хуулийн 39.1-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй:

39.2.1.компанийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, саналын эрхийн мэдээлэл;

39.2.2.компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

39.2.3.компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

39.2.4.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлого, цалин, урамшууллын хэмжээ;

39.2.5.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журам, процесс, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний мэдлэг, чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

39.2.6.компанийн сүүлийн 5 жилийн хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

39.2.7.компанийн улирлын болон жилийн үйл ажиллагааны тайлан;

39.2.8.компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

39.2.9.компанийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

39.2.10.компанийн үйл ажиллагаа, удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээ;

39.2.11.аудитын хорооны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн үнэлгээ, аудитын дүгнэлт;

39.2.12.аудитын хорооны дүгнэлт, тайлан;

39.2.13.компанийн эсрэг эсхүл компанитай холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн фирмийн талаарх мэдээлэл;

39.2.14.компанийн дүрэм, компанийн үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журам;

39.2.15.тухайн жил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын болон бусад үйл ажиллагааны мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн байдал;

39.2.16.бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын талаарх мэдээлэл, нийлүүлэгч этгээд, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, явц;

39.2.17.төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

39.2.18.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

39.2.19.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан болон бусдад өгсөн дэмжлэг, хандив, тусламж.

39.3.Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан компанийн мэдээлэлд хяналт шалгалт хийх зорилгоор холбогдох бичиг баримтыг хуулбарлахыг зөвшөөрнө.

39.4.Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдсэн цахим хуудсанд байршуулна. Нэгдсэн цахим

хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.

39.5.Энэ хуулийн 39.1, 39.2, 39.4-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

40 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

40.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁸, эсхүл Зөрчлийн тухай хууль⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

41 дүгээр зүйл.Дагаж мөрдөх журмын зохицуулалт

41.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйл ажиллагаа явуулж байсан хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгүүлэх боломжгүй нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд компани хэлбэрт шилжүүлнэ.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт сургууль, эмнэлэг хамаарахгүй.

42 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

42.1.Энэ хуулийг 2022 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

⁸Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁹Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ДАГАЖ ГАРАХ ХУУЛИЙН ТАЛААРХ САНАЛ

Д/д	Дагалдах хуулийн төслийн жагсаалт	Үндэслэл, агуулга
1.	Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид хамаарах заалтыг хасна.
2.	Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	Энэ хуулийн зохицуулалтыг хуулийн төсөлд оруулж байгаа болно.
3.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	4.1.1.аж ахуйн тоцоот үйлдвэрийн газар гэснийг хасах
4.	Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Үйлдвэрийн газар гэснийг хасах, үйлдвэрийн газар гэснийг компани гэж өөрчилнө.
5.	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	3.2 улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар, гэснийг хасах
6.	Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	7.1.1 "... хуулийн этгээд, төрийн өмчийн үйлдвэрийн газар" гэснийг "болон төрийн өмчит компани" гэж өөрчлөх
7.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	11.4-ийг хасах, 16.9, 20.4, 22.3-ыг өөрчлөх
8.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	34.25.2, 34.27 дэх хэсгийн Хуулийн этгээд, аж ахуйн нэгж гэснийг компани гэж өөрчилсөн.
9.	Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	45.7 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гэснийг компаниар гэж өөрчлөх
10.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Үйлдвэрийн газар гэсэн хуулийн этгээдийн хэлбэрийг хассан тул хасах 7 дугаар зүйл
11.	Шилэн дансны тухай хууль	Үйлдвэрийн газар гэсэн хуулийн этгээдийн хэлбэрийг хассан тул 3.1.2-ыг хүчингүй болгох

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
Улаанбаатар
сарын ... -ны өдөр

хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙ, НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуй, нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дампуурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “үйлдвэрийн газрын” гэснийг “компанийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Дампуурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “хуулийн этгээд, төрийн өмчийн үйлдвэрийн газар” гэснийг “болон төрийн өмчит компани” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 3 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн “улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйлийн 16.9 дэх хэсэг:

“16.9.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрд ногдох хувьцаа эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн компанид ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн компани, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.”

2/20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг:

“20.4.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.”

3/22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“22.3.Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит компанид өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно.”

2 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.25.2 дахь заалтын “аж ахуй нэгжийн” гэснийг “компанийн” гэж, мөн зүйлийн 34.27 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “компани” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн "аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар" гэснийг "компаниар" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 7.1.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Компанийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/61 дүгээр зүйлийн 61.5 дахь хэсэг:

“61.5. Хувьцааных нь шаардлагатай багцаас багагүй хэмжээг нь төр эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.”

2/61 дүгээр зүйлийн 61.11 дэх хэсэг:

“61.11. Хувьцааных нь шаардлагатай багцаас багагүй хэмжээг нь төр эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 61.5-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.3. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны онцлог харилцааг тусгайлсан хуулиар, уг хуульд өөрөөр заагаагүй бол компанийн нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна.”

3 дугаар зүйл. Компанийн тухай хуулийн 61.5-61.9 дэх хэсгийн дугаарыг “61.6-61.10”, 61.10 дахь хэсгийн дугаарыг “61.12” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн “компани болон төрийн өмчийн” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4-2.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, 36 дугаар зүйл, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэг, 79 дүгээр зүйлийн 79.2, 79.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.